



ӨНХӨРЧ



СУРСАН

НЬ





БЯЦХАН ЗАРАА ХЭЦҮҮХЭН АСУУДАЛТАЙ ТУЛГАРАВ.



ТЭР МАШ БАТ БӨХ ҮСТЭЙ, БАС ҮНЭХЭЭР ХУРДАН ГҮЙЖ ЧАДДАГ ЮМ.




ХАРИН ТҮҮНД ХИЙЖ ЧАДАХГҮЙ НЭГ Л ЗҮЙЛ БАЙЛАА.




БАС ТЭР ЭНЭ ЗҮЙЛИЙГ ЗААВАЛ ХИЙЖ СУРАХ ЁСТОЙ БАЙВ.



    Зүйл

ЭНЭ БОЛ ЗАРААНУУДЫН ЗААВАЛ ЧАДДАГ ЗҮЙЛ

   

БОЛОХ ЯГ Л БӨМБӨГ ШИГ ӨНХӨРЧ ЧАДДАГ

       

БАЙХ ЧАДВАР ЮМ. ГЭВЧ БЯЦХАН ЗАРАА ЯАЖ БӨМБӨГ ШИГ

  

ӨНХӨРӨХИЙГ ҮНЭНДЭЭ ОЙЛГОХГҮЙ Л БАЙЛАА.





ЭЭЖ НЬ ТҮҮНД "НАМАЙГ ЯАЖ ӨНХРӨХИЙГ ХАРААРАЙ"



ГЭЖ ХЭЛЭВ. БЯЦХАН ЗАРАА ЭЭЖИЙГЭЭ БИЕЭ ХЭРХЭН



ЭВХЭЖ БАЙХЫГ АНХААРАЛТАЙ АЖИГЛАЛАА. ТЭГЭЭД БЯЦХАН



ЗАРАА ЭЭЖТЭЙГЭЭ АДИЛХАН ОРОЛДОЖ ҮЗЭХЭД



ТҮҮНИЙ САНАСНААР БОЛСОНГҮЙ.



ААВ НЬ ТҮҮНД "ЧИ ЯМАР НЭГ БӨӨРӨНХИЙ ЗҮЙЛИЙГ ӨӨРӨӨ

ДОТРОО ТӨСӨӨЛ. ТЭГЭЭД ДАРАА НЬ ТӨСӨӨЛЛӨӨ ДАГААД

БӨМБӨЛӨГ АДИЛ БИЕЭ ЭВХ“ ГЭЖ ХЭЛЭВ. БЯЦХАН ЗАРАА

БӨӨРӨНХИЙ САРНЫ ТУХАЙ, ӨӨРИЙН ДУРТАЙ БӨӨРӨНХИЙ ЧУЛУУНЫ

ТУХАЙ БОДЛОО. ТЭГЭЭД ӨНХРӨХ ГЭЖ ДАХИН ОРОЛДСОН Ч БАС Л ЧАДСАНГҮЙ.



   

ЭЦЭСТ НЬ БЯЦХАН ЗАРАА ӨӨРӨӨ

  

ӨНХӨРЧ СУРАХААР ШИЙДЭВ.

   

ТЭР ДЭЭШ ҮСРЭН ӨӨРӨӨ БӨӨРӨНХИЙ

 

БОЛОХООР ОРОЛДОЖ ҮЗЛЭЭ.




ТЭР


ЧУЛУУ


НАЛАН


БИЕЭ


ЭВХЭЖ


БӨӨРӨНХИЙ


БОЛОХООР


ОРОЛДОВ.



ГЭСЭН Ч ЧАДАХГҮЙ ХЭВЭЭРЭЭ Л БАЙСАН ТУЛ ТҮҮНИЙ

УРАМ ХУГАРЧ ЭХЭЛЛЭЭ. ТЭГТЭЛ БЯЦХАН ЗАРААД

ГЭНЭТ 1-н НЭГЭН МЭРГЭН САНАА ОРЖ ИРЭВ. ТЭР

ӨӨРИЙГӨӨ БӨМБӨГ АДИЛ БОЛГОЖ ЧАДАХ Л ЮМ БОЛ ЯГ Л

БӨМБӨГ ШИГ ӨНХӨРЧ ЧАДНА ГЭДГЭЭ ОЙЛГОЛОО.





ТЭР ӨӨРИЙГӨӨ БӨМБӨГ ШИГ БОЛГОХЫН ТУЛД ЯГ ЯАХ



ЁСТОЙГОО ТӨСӨӨЛӨН БОДЛОО. ЭХЛЭЭД ТОЛГОЙГОО



БӨХИЙЛГӨВ. ТЭГЭЭД ХӨЛӨӨ НУГАЛАВ. ТЭГЭЭД БИЕЭ



ХУМИХАД ЯГ БӨМБӨГ ШИГ БОЛОВ. ДАРАА НЬ



БЯЦХАН ЗАРАА ГҮНЗГИЙ АМЬСГАА АВААД ӨНХӨРЧ ЭХЭЛЛЭЭ.



   

ТИЙМЭЭ. ТҮҮНИЙ ЗӨВ БАЙХ НЬ ТЭР!





БЯЦХАН ЗАРААГИЙН ААВ ЭЭЖ НЬ ТОЛГОДЫН ДЭРГЭД



ТҮҮНИЙГ ХҮЛЭЭЖ БАЙЛАА. ААВ НЬ "ЧИ ӨНХӨРЧ



ЧАДЛАА" ГЭЖ ХЭЛЭВ. "БИД ЧАМАЙГ ӨНХӨРЧ ЧАДНА



ГЭДГИЙГ МЭДЭЖ БАЙСАН" ГЭЖ ЭЭЖ НЬ ХЭЛЭВ.



БЯЦХАН ЗАРАА Ч ӨӨРӨӨ ӨНХӨРЧ ЧАДНА ГЭДГЭЭ МЭДЭЖ БАЙЛАА.